

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН
САНГИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын 23.

Улаанбаатар хот

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээ мэдээллийг түгээх, тэдэнд зориулсан соёл танин мэдэхүй, соён гэгээрүүлэх, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн ажлуудыг дараах байдлаар зохион байгуулан ажиллаа.

3.1 Хүрээлэн буй орчны тогтвортой хөгжил

3.1.4. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах “Утаагүй хот 2030” төсөл хэрэгжүүлж, хүрэх үр дүнг тодорхойлно.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 дугаар захирамжаар, 2019 оны “Түүхий нүүрсний тээвэрлэлт хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”, “Нийслэл дүүргийн онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”-ийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09:00 цагаас 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цаг хүртэл, 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 09:00 цаг хүртэл, Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн захирал Д.Индрагийн удирдлага дор давхардсан тоогоор 28 хүнтэй ажлын хэсэг 24 цагийн хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэж Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд ажиллаж байгаа шуурхай штабын жижүүрүүдтэй 09:30, 12:30, 18:30, 22:30 цагуудад холбогдож, сайжруулсан түлшний хангамжийн мэдээллийг авч нийлүүлэлт дээр анхаарч ажилласан. “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийн байранд тус номын сангийн Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн эрхлэгч Б.Санжаасүрэн, програмист О.Цог, захирал Д.Индра ажилласан бол тус номын сангийн 22 албан хаагчид 5 хэсэгт хуваагдан Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн түлшний дундын цэгүүд, борлуулалтын цэгүүдэд биечлэн хяналт тавьж ажилласан.



4.3. Соёл, урлаг

4.3.2. Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийлээ.

Тус номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2019 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 100,000,000 төгрөгийг шийдвэрлэн Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдөр тендер зарлагдан “Ай Ти Зон” ХХК шалгарсан. Тус компанитай 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр “Төв болон салбар номын санд RFID системийн компьютер, бусад тоног төхөөрөмж нийлүүлэх” гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн дотор тоног төхөөрөмжийг хүлээн авч 2020 оны тайлангийн хугацаанд салбар номын сангуудад RFID /цахим номын сан/ технологийг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа ба Баянзүрх дүүрэг дэх салбар номын санд 25000 ширхэг номноос 19150 ширхэг номонд ялтас / Tag/, Хан-Уул дүүрэг дэх салбар номын санд 20000 ширхэг номноос 12300 ширхэг номонд ялтас / Tag/, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын санд 40000 ширхэг номноос 25365 ширхэг номонд ялтас / Tag/ нийт 87,088 ширхэг номонд ялтас суулгаад байна. Дараагийн 15000 ширхэг номонд ялтас суулгахаар жагсаалт үүсгэн байрлуулсан.



4.3.2. УБХНТНСан болон салбар номын сангууд, дүүргүүдийн соёлын ордны номын сангуудад фондын баяжилт хийнэ

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх шаардлагатай ном хэвлэлийн судалгаа гарган, холбогдох бичиг баримтуудыг бүрдүүлж, холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэхээр өгсөн байна. 2020 хагас жилийн байдлаар 245 нэрийн 763 ширхэг 8,845,200 төгрөгийн номыг бэлэг хандиваар, 3 нэрийн 40 ширхэг 600,000 төгрөгийн номыг худалдаагаар нийтдээ 248 нэрийн 776 ширхэг 9,445,200 төгрөгийн номыг тус тус бүрдүүлэн авч фондын баяжилт хийгдсэн.

4.5 Хүүхэд, гэр бүлийн хөгжил

4.5.10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд “Би хариуцлагатай аав ээж” аяныг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Төв болон салбар номын сангийн хүүхдийн уншлагын танхимын номын санчид харьяа дүүргийн ГБХЗГ-тай байнга хамтран ажилладаг. Ковид 19 цар тахлын нөхцөл байдлын улмаас нийтийг хамарсан үйл ажиллагааг зогсоосон тул манай байгууллагаас

уншигч эцэг эхчүүд болон хүүхдүүдэд зориулсан соёл танин мэдэхүйн ажлыг байгууллагын пейж хуудас, веб сайтаар дамжуулан цахимаар эрчимтэй хүргэж ажиллалаа. Үүнд бүтээлч орон зайн төвийн сургалт, видео контент – 17 удаа, хүүхдийн уншлагын танхимаас зохион явуулах уулзалт, үлгэрийн цаг – 25 удаа, Д. Нацагдоржийн шагналт зохиолч, уншигчийн уулзалт, Live “Номын сангийн зочин” ярилцлага – 19 удаа, Монголчуудын хэрэглэж байсан бичиг үсгийн цахим номзүй – 5 удаа, Зуны амралтаар унших номууд цуврал ном зүй – 7 удаа, Ном унших дадал, цаг үеийн шинж чанартай мэдээллийн шинж чанартай 62 постыг тус тус хүргэн ажиллалаа.



4.8 Нийгмийн халамж

4.8.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын барилга байгууламж нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, дэд бүтэц, ээлтэй орчин бүрдсэн эсэхэд хийгдсэн үнэлгээний дагуу хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Төв номын санд байрладаг харааны бэрхшээлтэй иргэдийн номын санд “Хүртээмжтэй технологиор дамжуулан, хараагүй хүмүүсийн мэдээлэл хүртэх боломжийг нэмэгдүүлэх” зорилт бүхий CANADA сан, хараагүй хүмүүсийн инноваци хөгжил ТББ-тай хамтран “Харааны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадваржуулах нь” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төслийн хүрээнд иж бүрэн компьютер 4 ширхэг, цахим брайль төхөөрөмж 4 ширхэг, дэйзи цахим ном тоглуулагч 4 ширхэг, сканер 2 ширхэг, утасгүй сүлжээний төхөөрөмж 2 ширхэг, чихэвч 4 ширхэг PC яригч 4 ширхэг, ширээ 4 ширхэг, сандал 4 ширхэг зэрэг эд хөрөнгийг авч уншлага үйлчилгээнд нэвтрүүлэв.

Мөн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой технологийн сургалтуудыг харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх танхимын номын санч болон харааны бэрхшээлтэй иргэдэд тус тус зохион байгуулсан. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан 50 нэрийн сурах бичиг, 5 нэрийн бусад шинжлэх ухааны нийт 55 нэрийн номыг E-PUB хүртээмжтэй форматаар тусгай хэрэгцээт боловсролын шаардлагад тохируулан бүрдүүлж үйлчилгээнд нэвтрүүлсэн. Мөн хараагүйчүүдэд үйлчлэх танхимын орох хаалга, ариун цэврийн өрөөнд засвар хийн тав тухтай үйлчлүүлэх боломжоор хангасан.



5.1 Оновчтой бүтэц, хариуцлагатай албан хаагч

5.1.7. Авилга албан тушаалын гэмт хэрэг, зөрчилд тавих олон нийтийн хяналтыг сайжруулна.

Авилгатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн тэргүүлэх нэгэн чиглэл нь авилгын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авилгын нийгэмд учруулах хор аюулыг олон нийтэд ухуулан таниулах, иргэдийг авилгатай тэмцэх арга барилд сургах, энэ төрлийн үйл ажиллагаанд татан оролцуулах юм. Энэхүү чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс авилгын эсрэг сургалт, сурталчилгаа, олон нийтийг хамарсан арга хэмжээг өмнөхөөс шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж байна. Үүний нэг нь авилгыг мэдээлэх 110 дугаарын хэлбэртэй номын булангаар дамжуулан авилгын тухай хууль тогтоомж, мэдээ мэдээлэл дамжуулж эхэлсэн.



Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр улс орон даяар уламжлагдан зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-үүдээр Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас цахимаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

Монголчуудын үсэг бичгийн видео товчоон, номзүй

Монголчуудын эртний бичиг үсэг болох Вагиндра, Хэвтээ дөрвөлжин үсэг, Али-Гали, Дөрвөлжин үсэг, Уйгаржин монгол бичиг тэдгээрийн үүсэл гарал, холбогдох ном зохиол, судалгааны бүтээл, дээрх бичиг үсгийн талаар судалсан эрдэмтэн судлаачид, түүх дурсгалын талаар видео бичлэгүүдийг олон нийтэд цувралаар хүргэсэн.

UB Public Library - Хотын Төв Номын Сан 7 May at 10:00 • 📺 Номын санч И.Энхтуяа Монгол бичгийн тухай түүхэн товч, уншиж, судлавал зохих гурван номыг нэрлэж байна... Үндэсний бичиг үсгийн баярт 	UB Public Library - Хотын Төв Номын Сан 6 May at 10:49 • 📺 Вагиндра үсгийн тухай: Түүхэн товчоон- Номзүй Үндэсний бичиг үсгийн баярт Номын санч Б.Шүрэнбагана 	UB Public Library - Хотын Төв Номын Сан 11 May at 11:04 • 📺 Уншигч танд Али- Гали үсгийн үүсэл гарал, уншвал зохилтой номын нэрсийг ахлах номын санч Ө.Бадамсэд хүргэж байна. Үндэсний бичиг үсгийн баярт. 
--	--	--

Уулзалт, сургалт, лайв

Хэл бичгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Ууганбаатар “Хэрхэн сайхан бичигтэй болох вэ?” лайв уулзалт хийн зөв сайхан бичих суртгалт явууллаа.

Үзэсгэлэн

Мөн “Монгол бичиг бидний бахархал, Монголчуудын бичиг үсгийн түүх” зэрэг монгол бичгийн гайхамшигийг харуулсан уран бичлэгийн зургийн хамт 20ш ном 19ш хэвлэмэл материалаар үзэсгэлэн гаргасан.



“Үндэсний бичиг үсэг” сэдэвт үзэсгэлэн үзэсгэлэнг 10ш ном, 10ш хэвлэмэл материал, 14ш бүтээлээр гаргаж суртчилсан.



Үндэсний бичиг үсгийн баяр арга хэмжээнд нийт 14ш бүтээл, 30ш ном, 29ш хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн гаргаж, цахимаар нийт 3612 хүн үзсэн байна.

2. Нийслэлийн Засаг даргын 2012 он “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/606 дугаар захирамж

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1348 жиргээ илгээгдэж, 465 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 39576, үүнээс гадна АСМТ 18547, ХУД 1162 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.

1	UB Public Library - Хот...	39.6K	▲0.1%	2	470
2	Монгол Улсын Үндэсний...	19.2K	▲0.3%	11	3.4K
3	American Corner, Ulaan...	18.5K	0%	1	71
4	Хүүхдийн төв номын сан	9.2K	▲0.2%	34	816



3. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Мэдээллийн аюулгүй байдлын журам” А/477 дугаар захирамж

Мэдээллийн системийг холбогдох стандартын дагуу зохион байгуулж ажилладаг бөгөөд номын сангийн үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй мэдээлэл, шилэн дансны мэдээллийг нийтэд ub.pl.gov.mn, UB Public Library Facebook цахим хуудсанд тухай бүрт байршуулж байна.

Байгууллага дотооддоо захирлын тушаал, үүрэг даалгавар, ажилтан, албан хаагчдын хувийн хэрэг, өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүдийг ажилчдын дотоод Facebook page болон дотоод сүлжээгээр мэдээллэдэг.

Номын сангийн нийт байр талбайн 10 хүртэлх хувь буюу үндсэн фонд болон Серверийн өрөө хаалттай бүсэд тооцогддог. Үндсэн номын фонд, серверийн өрөөнд зөвхөн эрх бүхий албан тушаалтан нэвтрэх эрхтэй бөгөөд аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажилладаг.


Ашиглагдаж байгаа бүх компьютер техник хэрэгслийг мэдээллийн ажилтнууд бүртгэлжүүлж, засвар үйлчилгээ, шинэ програм хангамж нэмэгдэх бүрт програмист болон хариуцагч ажилтан нар гарын үсэг зурж баталгаажуулдаг.

Мэдээллийн системийг хууль бус халдлагаас хамгаалах галт хана ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, илрүүлэх зориулалтаар хамгаалалт, хяналтын техникийн систем, зориулалтын програм хангамжинд байнга хяналт тавьж ажиллаж байна.

4. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж

Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт

<http://koha.pl.ub.gov.mn> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2019 оны 12 дугаар сарын 25-аас 2020 оны 06 дугаар сарын 08-нийг хүртэлх хугацаанд 48391 хэрэглэгч зочилж /visits/, 134276 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 84,6% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 15,4% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсан хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.

Country	Users	% Users
1. Mongolia	43,687	88.76%
2. United States	2,676	5.44%
3. (not set)	878	1.78%
4. South Korea	404	0.82%
5. Japan	277	0.56%
6. Russia	250	0.51%
7. China	143	0.29%
8. Germany	97	0.20%
9. United Kingdom	85	0.17%
10. Australia	57	0.12%


Вэб хуудас

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн вэб <http://www.pl.ub.gov.mn> -ийн агуулгыг шинэчлэн сайжруулахад анхаарч ажиллаж байгаа бөгөөд шинээр 26 мэдээ мэдээлэл оруулж ажиллаа. Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг 2020 оны 12 дугаар сарын 25-аас 2020 оны 06 дугаар сарын 17-нийг хүртэлх хугацаанд тайлан гаргахад 36830 хэрэглэгч зочилж /visits/, 137866 хуудасны мэдээллийг үзсэн байна. Нийт сайтийн хэрэглэгчдийн 76.7% нь шинээр орж, 23.3% нь хуучин хэрэглэгчид зочилсон байна.

СТАТИСТИКА

197866

Visit Today : 46
Visit Yesterday : 179
This Month : 1894
This Year : 36830
Total Visit : 197866
Who's Online : 6



5. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай” А/633 дугаар захирамж

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн 12, шинээр болон эгүүлэн томилогдсон 7, шилжин ажилласан 4 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

6. Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай” А/252 дугаар захирамж

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 112 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 110, цаасан суурьтай 3 албан бичиг ирснийг бүртгэсэн. 111 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хааж, 2 албан бичиг судалж буй төлөвтэй байна.

Тайлант хугацаанд Edoc системээр нийт явуулсан 85 албан бичгийг бүртгэсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 79, систем ашиглагдаггүй 6 байгууллага руу албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн.

Систем ашиглалтын зөрчилтэй 2, хяналтын зөрчилтэй 7 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад 12 удаа танилцуулж ажилласан.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Уншлага үйлчилгээ

Салбар номын сангийн хэмжээнд 2020 оны эхний хагас жилийн байдлаар бүтээгдэхүүн нийлүүлэлтийг “хүснэгт 1”-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Бүртгэлтэй уншигч	9700	2616	27%
2	Ирц	129300	11934	0.9%
3	Ном олголт	299250	16709	0.6%
4	НИЙТ ДҮН	438250	31259	0.7%

Тайлбар


1. Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын улмаас Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот хурлын шийдвэрээр соёлын байгууллагуудын үйл ажиллагааг хааснаар манай байгууллага дотооддоо цахимаар ажиллах ажиллаж эхэлсэн.

2. Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд 5 удаагийн тооллого /Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан, төв номын сангийн уншлагын А танхим/ хийгдсэн.

3. Тус номын сангийн хэмжээнд RFID системийг нэвтрүүлж байгаатай холбоотойгоор “А”, “Б” танхим, Хүүхдийн уншлагын танхим, Ном зүйн фондын ном, Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудын нийтийн болон хүүхдийн уншлагын танхимын нийт 87,888 ширхэг номын мэдээллийг Коха програмын электрон каталогт засвар хийн, ном зүйн стандартыг хангаж ажилласан. Мөн 87,88 номонд RFID-ийн ялтас суулгаж идэвхжүүллээ.

3.2. Гэрээр ном олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд уншигч хэрэглэгчдэд **39662** ном хэвлэл олгож үйлчилснээс 3316 ширхэг номыг гэрээр олгож үйлчилсэн байна.



3.3. Солилцоо болон зөөврийн үйлчилгээ

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу **11** удаа **718** ширхэг номоор үйлчилгээ үзүүлээ.

- ХУД-ийн 120-р цэргийн ангитай 44 номоор 2 удаа
- Оюунлаг төрийн албан хаагч аяны хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 50 албан хаагчид уншигчийн үнэмлэх нээлгэн 127 номоор 3 удаа
- Багануур дүүргийн Соёлын ордны номын сантай 54 номоор 2 удаа
- ХУД-ийн 13 хороонд байрлах зэвсэгт хүчний 120-р цэргийн ангитай хамтарч 15 ширхэг номоор 1 удаа
- “Ном хөтөлбөр”-ийн хүрээнд Идэр их сургуультай зөөврийн номын сангийн гэрээ байгуулан 46 ширхэг номоор 1 удаа
- ХУД-ийн байрлах зэвсэгт хүчний 126-р цэргийн ангитай хамтарч 20 ширхэг номоор 1 удаа зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байна.
- Сэлэнгэ аймгийн Хушаат сумын соёлын төвийн номын санд хүргэлтээр 60 номоор 1 удаа



Номын солилцоог “Өргөө” амаржих газрын номын сантай 25 ш номоор 2 удаа, Хилийн цэргийн 151-р ангийн номын санчтай 17 ш 1 удаа тус тус хийж 59 удаа уншлага үйлчилгээнд гарган уншуулж, уншигчдын эрэлт хэрэгцээг цаг алдалгүй ханган үйлчилж ирлээ.


3.4. Интернет үйлчилгээ

Төв номын сан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргүүдэд тус бүрт уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернэтийн үйлчилгээг үнэ төлбөргүй, харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерийг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон.

Тайлангийн хугацаанд Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудын интернетыг Ситинэт ХХК-ны 2Mbps dedicated хурдаар шилэн кабелин гэрээ байгуулсан.


Үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 97,38 Mbps, дунджаар 3,37 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 66,96 Mbps, дунджаар 395,65 Kbps хүрсэн байна.




Утасгүй Интернэтийн сүлжээ

Утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 45.40 Mbps, дунджаар 10.2 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 25.79 Mbps, дунджаар 128.37 Kbps хүрсэн байна (Зураг(2.3-2)).




Америкийн Соёл Мэдээллийн Төв, Хөтөлбөрийн өрөөний Утасгүй Интернэтийн сүлжээ

Утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж /download/ байгаа хурд хамгийн ихдээ 79.28 Mbps, дунджаар 1.02 Mbps, түгээж /upload/ байгаа хурд хамгийн ихдээ 54.28 Mbps, дунджаар 134.74 Kbps хүрсэн байна.



Хан-Уул дүүрэг дэх салбарын Үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 72.21 Mbps, дунджаар 685.85 Kbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 17.45 Mbps, дунджаар 70.60 Kbps хүрсэн байна.



Тайлангийн хугацаанд Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот хурлын шийдвэрээр соёлын байгууллагуудын үйл ажиллагааг хааснаар манай байгууллага дотооддоо ажиллаж эхэлсэн. Иймд суурин болон утасгүй интернэтийн хэрэглэгч байхгүй. Төв болон салбар номын сангуудын интернэт үйлчилгээ хэвийн жигд явагдаж байна

3.5. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

2020 оны эхний хагас жилийн байдлаар 245 нэрийн 736 ширхэг 8,845,200 төгрөгийн номыг бэлэг хандиваар, 3 нэрийн 40 ширхэг 600,000 төгрөгийн номыг худалдаагаар нийтдээ 248 нэрийн 776 ширхэг 9,445,200 төгрөгийн номыг тус тус бүрдүүлэн авч, 776ш номонд техник ажиллагаа хийж, 248 нэрийн 776ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 744ш баркод хэвлэсэн байна. Бүрдүүлэлтээр авсан бүх номуудыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүллээ.




Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, энэ оны эхний хагас жилд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 21 нэр төрлийн 1,943,600 төгрөгийн хэвлэл захиалсан байна.

Урагдаж гэмтсэн нийт 265ш ном хэвлэлийг сэлбэн засаж, төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 104 нэгж болгон хавтасласан, үнэлгээ тогтоогоогүй байсан 1884 ширхэг судар номонд үнэлгээ тогтоож, данс бүртгэлжүүлээ.

Лавлагаа, номзүйн үйлчилгээ

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны цахим болон утсаар, амаар нийт **535** удаа лавлагаа өгсөн байна.



Номзүй

- Ковид-19 буюу коронавирусын халдвар ихссэнтэй холбогдуулан “Вирусын чиглээлээр уншвал зохих номууд”-ын жагсаалтыг гаргаж нийгмийн сүлжээгээр олон нийтэд түгээлээ.
- Зотеро программыг ашиглан Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Засгийн газрын мэдээ, Монголын мэдээ, Үнэн, Үндэсний шуудан зэрэг сонингууд дээр “Covid -19”-ын тухай 1-4 сар хүртэл гарсан 1500 орчим мэдээллийг түүвэрлэж номзүй хийхээр бэлдээд байна.
- Мөн С.Буяннэмэх судлалаар эрдмийн зэрэг хамгаалахаар ажиллаж буй Л.Амаржаргаланд С.Буяннэмэхийн номзүйг илгээлээ.
- Мэдээлэл номзүйн ажлын хүрээнд “Жаран цагаан хонь”, “Ногоон нүдэн лам”, “Гүйж яваа эмэгтэй”, “Хүн шувуу”, “Ухаантай хүүхдийн ухаалаг ном”, “Хөвгүүдий унших сонгодог зохиолууд”, “Хорвоотой танилцсан түүх”, “Бөөгийн домог”, “Судасны чимээ”, “Могой цэцэг”, “Шүгдэн”, “Сахиуст хангайн нууц”, “Дүрсгүй жаалын өдрийн тэмдэглэл”, “Дуу чимээ”, “Өнгө дүрс”, “Үгс”, “Манай дэлхий”, “Сурагчийн нэвтэрхий толь”, “Дэлхийн 365 нээлт”, “Паулын гудамжны хөвгүүд” зэрэг 20 гаруй номын мэдээллийг номын сангийн пэйж болон вэб хуудсаар дамжуулан уншигчдад танилцууллаа.

3.1.3. Ном хэвлэл сэлбэн засах

Урагдаж гэмтсэн нийт **1354 ш** номыг хэвлэлтийн анхны жинхэнэ хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан байна. Үүнд:

- Сэлбэн засагч 265 ш ном
- Төв номын сан 30 ш ном
- ЧД дэх салбар номын сан 734 ш ном
- ХУД дэх салбар номын сан 270 ш ном
- БЗД дэх салбар номын сан 30 ш ном
- СХД дэх салбар номын сан 25 ш ном тус тус сэлбэн зассан байна.

Төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 104 нэгж болгон хавтасласан байна.

Отгонтэнгэр Их сургуулийн номын санчдад номзүйн "Зотеро програмын тухай" арга зүйн зөвлөгөөг Олон нийтэд үйлчлэх тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох, ном зүйч О.Долгорсүрэн нар өөрийн байран дээр нь очиж өглөө. Мөн Увс аймгийн номын сангийн номын санч, Монгол Япон төвийн номын санчдад Коха программын уншигч бүртгэл, үүдний хяналт, ном олгох, буцаах тал дээр бүртгэл мэдээллийн ажилтан Б.Мөнхзул, угтах үйлчилгээний ажилтан Г.Ариунзаяа, Ахлах номын санч Ө.Бадамсэд, номын санч Д.Сарантуяа, тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох нар танилцуулж, мэдээлэл өглөө.




3.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ

Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ

2020 оны эхний хагас жилд 12 ирцэд 40 номыг гэрээр олгож үйлчилсэн байна.

Дэлхийн номын баяраар Ж.Уэтерфордын “Монголын их хатдын нууц товчоо” номоор идэвхтэн уншигч А.Сайханцэцэгтэй “Номын далайд хамтдаа аялъя” сэдэвт LIVE уулзалтыг зохион байгуулж тус уулзалтанд 667 хүн онлайнаар холбогдсон байна.

Тээврийн цагдаагийн албатай хамтарч “Замын хөдөлгөөний дүрэм”-ийг брайль болон томруулсан форматаар хэвлэж сурталчилсан.



“Дөрвөн бэрх - Шагайн мэргэ” тайлбарыг брайлиар хэвлэн гаргаж сурталчилсан.



Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан DAISY төв

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан (Daisy) стандартад нийцүүлэн E-PUB 50 ширхэг цахим ном бүтээсэн.

Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний албан ёсны facebook хуудсанд 30 удаагийн мэдээ мэдээлэл оруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн “youtube” сувагт 30 удаагийн дүрстэй мэдээлэл оруулсан байна.

3.2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

3.2.1. Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоож номын сангийн ажилтнуудад зориулсан гадаад болон дотоодийн бүх сургалтууд цуцлагдсан.

3.2.2. Тус номын санд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

3.2.3. Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 45,7% буюу 32 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, 1 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан. Ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

3.2.4. Захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд байгуулсан Хамтын гэрээн 6.7-д “Ажилтнуудыг 2 жилд 1 удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах...” гэж заасны дагуу 2019 онд байгууллагын 55 ажилтныг Хавдар судлалын үндэсний төвийн эмнэлэгт урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Мөн нийт албан хаагчийг томуу, томуу төст өвчлөл, тоосны харшлаас сэргийлэх, дархлаажуулах зорилгоор витаминжуулалтын аянг зохион байгууллаа.



3.3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт


Тайлант хугацаанд 10 өргөдөл ирснээс ирснийг бүртгэлийн дэвтрээр болон UB ERP цахим системд бүртгэн 100 хувь барагдуулж ажилласан.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 2 удаа гаргаж НЗДТГазар руу хүргүүлж ажилласан.

Дөрөв. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Үйл ажиллагааны ил тод байдал:

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай **26** холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаараа мэдээлсэн.



Номын сангийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэх батлах тухай” А/01 дүгээр тушаалыг, үйлчилгээ авахад шаардах баримт бичгийн жагсаалт болон холбогдох мэдээллийг хамт ойлгомжтой байдлаар цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан байгаа. Номын сангийн тухай хууль, Номын сангийн үйлчилгээний журмыг уншигчдад ойлгомжтой байдлаар зурган болон видео бичлэгээр хийж вэб сайт, мэдээллийн самбар, нийгмийн сүлжээ, номын сангийн үүдэнд байрлах дэлгэцээр тус тус сурталчиллаа.

Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

4.2. Хүний нөөцийн ил тод байдал:

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг тухай бүр байршуулан шинэчилж байгаа.

Тайлант хугацаанд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

Тав. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Соёл, олон нийтийн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг цахимаар зохион байгууллаа.


Үүнд:

д/д	Үйл ажиллагааны ерөнхий нэр	Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Уулзалт лекц	22	2216
2	Сургалт	24	56
3	Зөвлөмж яриа	2	3240
4	Чанга уншлага	2	48
5	Кино үдэш	1	40
6	Номын үзэсгэлэн	16	745
7	Бусад	33	36439
	НИЙТ	100	72484

Эдгээрээс тоймлон үзвэл:

Уулзалт, лекцийн чиглэлээр:

- Дэлхийн номын өдрийг тохиолдуулан хүүхдийн уншлагын танхимын номын санчид хүүхдийн зохиолч О.Сундуйтай хамтран “Хүүхдийг хэрхэн номонд дуртай болгох вэ” сэдэвт уулзалтыг цахимаар хийлээ.
- Мөн Дэлхийн номын өдрийг тохиолдуулан “Бүжинд тохиолдсон явдлууд-1, 2, 3, 4” номын зохиогч Б.Индра, “Хачин бодлууд” номын зохиолч М.Цогтхун нарыг “Бүтээлч багачууд” нэвтрүүлэгтээ урьж оролцууллаа. Уг булангаар 33 дугаар сургуулийн сурагч Ш.Мандарваа уншигч багачуудад маань зориулан “Сохор номин” шүлгийг уран уншлаа.



Америкийн соёл мэдээллийн төвөөс:

“Америкийн тухай ярилцъя” цуврал лекц дараах 5 сэдвээр явагдсан.

- Таротын картууд ба арга замууд дэлхийн хэмжээнд цар хүрээг хэрхэн хөгжүүлэх тухай
- Америкийн хөгжмийн цувралаас
- АНУ-н соёлын хадгалалт Монголд
- Америкийн үндэстнүүд: Бүс нутгийн түүхүүд өөр үнэт зүйлд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Айова дахь Кавказууд хэрхэн ажилладаг талаар зэрэг лекцүүд тус тус зохион байгуулагдаж 156 хүн хамрагдлаа.

“Америкийн тухай ярилцъя” цуврал лекцийг танхимаар зохион байгуулахаас гадна Фэйсбүүк лайваар дараах 4 сэдвээр хийж хүргэсэн.

- Академи авардс шагналын тухай
- Голдсборо хотын түүх, Хойд Каролина
- Америкийн пароди буюу инээдмийн түүх
- Хөөрхөн төрхний талаарх түүний үүсэл гарал зэрэг лайвыг тус тус хийж 1580 хүнд хүргэлээ.

Монгол судлалын чиглэлээр “Үлэг гүрвэлийн өсөлт”, “Монгол орны малчин, тариаланчдын ирээдүйн талаар” гэсэн сэдвийн дор 2 удаагийн лекц зохион байгуулж 110 хүнийг хамрууллаа.

Сургалт:

- Англи хэлний ярианы клуб 2 удаа зохион байгуулагдаж 98 хүн хамрагдсан



- Англи хэлний багш нарт зориулагдсан англи хэлний заах арга зүйн сургалт 2 удаа явагдаж 44 хүн хамрагдсан.




- Англи хэлний илтгэлийн клуб 4 удаа зохион байгуулагдаж 174 хүн хамрагдсан



- Монголын ЛГБТ төвийн сургалт 1 удаа зохион байгуулагдаж 14 хүн хамрагдсан
- Лего тоглоомын хөтөлбөр 18 удаа явагдаж 23 хүүхэд хамрагдсан.
- Дахин загварчилах сургалт 3 удаа танхимаар зохион байгуулагдсан. Үүнд:
 - Хуванцараар ээмэг хийх сургалт 1 удаа 5 хүн
 - Хаягдал хувцас ашиглан ариун цэврийн хэрэглэл хийх 1 удаа 12 хүн
 - Хуванцараар хүзүүний зүүлт хийх 1 удаа 16 хүн тус тус хамрагдлаа.

Зөвлөмж яриа:

- Бага насны хүүхдийн хөгжил судлаач Л.Дэлгэрмаатай хамтран “Бага насны хүүхдийн хүмүүжил, хөгжил” сэдвээр эцэг эхчүүдэд зориулан лайваар зөвлөмж өглөө.
- Монголын Хүүхдийн зохиолчдын холбооны тэргүүн Н. Энхтайваныг урьж Бага насны хүүхдэд уран зохиолын ном уншуулах тухай лайваар зөвлөмж, ярилцлага хийлээ.



Чанга уншлага:

- Сайн дурын ажилтан М. Нинжинтэй хамтран 5-р ангийн нийт 16 сурагчдад Малала Юсуфзайгийн “Малалагийн шидэт харандаа”, “Сурах эрхийн төлөө” зэрэг номнуудаар номын тухай ярилцлага хийж, Малала охины тухай богино хэмжээний баримтат кино үзүүлж чанга уншлага хийв. К.Ямадагийн “Бэрхшээл гэж юу вэ” номын танилцуулга хийв.
- Сант сургуулийн Ю.Шижиртуяа багштай 6б ангийн 32 сурагчдад зохиолч Б.Уранболорын “Би өөрөө зохиолч болно” номын танилцуулга болон зохиолчтой уулзалт хийн чанга уншлага хийв.



Кино үдэш:


Кино үдэш хөтөлбөр 1 удаа зохион байгуулж 40 хүнийг хамрууллаа.



“Номын сангийн зочны ярилцлага” буланд:

- Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханы “Соёлт хүн төрөлхтөн оршин байгаа цагт ном зохиол унших соёл байсаар байна гэдэгт би огтхон ч эргэлздэггүй”
- МУИС-ийн Номын сангийн захирал Д.Цэрэнгийн “Олон жилийн дараа эргээд харахад ном их уншдаг байсан хүүхдүүд илүү зөв хандлагатай, ертөнцийг үзэх үзэл нь зөв тогтсон, бусдын хайрыг татсан, бусдыг хайрлаж чаддаг хүмүүс болон төлөвшсөн харагддаг”
- Тагтаа хэвлэлийн газрын үүсгэн байгуулагч, орчуулагч Б.Баясгалангийн “Уншигч байна гэдэг давын өмнө цүнхэндээ байнга нэг номтой явахыг л хэлнэ, өөр сүйдтэй жор байхгүй”
- Орчуулагч Б.Баярсайханы “Ном болгон хүнд шинэ ертөнцийг нээж өгдөг”

- Түүхийн ухааны доктор Б.Баатархүүгийн “Өнөөдөр залуучууд цахим орчноос мэдээлэл их авдаг болж, тэр дундаа үнэн зөв эсэх нь эргэлзээтэй элдэв янзын бохир мэдээллээр тархиа цэнэглэж байгаад тун харамсдаг”
- МУИС-ийн Ази судлалын тэнхимийн багш, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн салбарын эрхлэгч Ц.Цэрэндоржийн “Бүхий л эрдэм мэдлэгийн суурь бол бичиг үсэг, ном унших түлхүүр нь ч бичиг үсэг”
- МУИС, Антропологи-археологийн тэнхимийн багш Ж.Лхагвадэмчигийн “Ном уншихын утга учир, үнэ цэнэ нь үнэн зөв, цэгцтэй мэдлэгтэй болох, тэр хэмжээгээр өөрийн үзэл бодолтой, задлан шинжлэх, шүүмжлэлт сэтгэхүйтэй болох, мэдэж ухаарсны хэмжээгээр өөрт болон өрөөлд тустай байхад оршино”
- СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэн, захирал Ш.Эрдэнэцэцэгийн “Ном бол Монгол түмний хэдэн мянганы туршид бүтээсэн соёлын үнэт зүйлийг хадгалж ирсэн бөгөөд цаашид сэргээх, уламжлуулах гол түлхүүр нь”
- Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн Баянзүрх салбарын эрхлэгч М.Отгонбаярын “Миний амьдралд үлгэрийн номууд маш чухал нөлөө үзүүлсэн”
- СУИС-ийн Соёлын сургуулийн Соёл судлалын судалгаа, сургалтын профессорын багийн багш Б.Мөнхбадралын “Хувь хүний сонирхлоос үл хамаараад эх орны түүх, хэл, соёл, газар нутаг, уул усны талаар ерөнхий мэдлэгтэй болох нь хүн бүрт маш чухал. Тэндээс хувь хүний, нийгмийн бүр үндэсний үнэт зүйл бүрэлдэн тогтоно” зэрэг 10 ярилцлагыг вэб сайтад нийтлэн олон нийтэд түгээлээ.



Номын үзэсгэлэн:

- Үндсэн хуулийн өдөрт зориулсан “Үндсэн хууль” үзэсгэлэн
- Шинэ номын үзэсгэлэн-2 удаа 14 нэрийн 27ш номоор
- “Ханиад томуунаас сэргийлье” үзэсгэлэнг 3ш ном, 6ш зөвлөмжөөр
- Утгын чимэг 2019 наадмын тэргүүн байрын шагналт, Төрийн соёрхолт Д.Норовын намтар болон зохиол бүтээлийн тэргүүн байрын 8ш номоор
- “Хэрээний нулимс” өгүүллэгийн хэсгээс 2ш хэвлэмэл хуудсаар
- “Хүүхдийн танин мэдэхүйн ном” үзэсгэлэнг 12 ш номоор
- “Хотын соёл хувь хүний соёлоос” сэдэвт үзэсгэлэнг 1978-2012оны 10ш ном, 4ш хэвлэмэл хуудсаар
- Аз жаргалтай-утаагүй Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд утааны тухай болон сайжруулсан түлш түүний хэрэглээний тухай үзэсгэлэнг 12ш номоор

- Нийслэлийн 2020 оны нэг хот – нэг стандарт ба хотын аяны хүрээнд дураараа бишээ дүрмээрээ, та замын хөдөлгөөнд соёлтой оролцоно уу? 28ш номоор
- “Дэлхийн бүжгийн өдөрт” 10 ном 2 хэвлэмэл хуудсаар
- “Дэлхийн номын баярын өдрийг” тохиолдуулан ковид 19 улмаас гэртээ байгаа хүмүүсийг уриалан “Гэр гэртээ номоо уншъя” үзэсгэлэн гаргаж Оросын алдарт зохиолч Ф.М.Достоевскийн монгол, орос хэл дээр хэвлэгдсэн 10ш ном, зохиолчийн намтар уран бүтээлийн тухай 3ш хэвлэмэл хуудсаар
- Үндэсний бичиг үсгийн баярын өдрөөр “Монгол бичиг бидний бахархал, Монголчуудын бичиг үсгийн түүх” монгол бичгийн гайхамшгийг харуулсан уран бичлэгийн зургийн хамт үзэсгэлэнг 20ш ном, 19 ш хэвлэмэл материалаар
- “Монгол бичиг үсгийн баяр 2020” үзэсгэлэнг 22ш ном, 10ш зурмал материал, 8ш хэвлэмэл хуудсаар
- Дэлхийн гэр бүлийн өдөрт 11ш номоор
- Монголын агаарын тээврийн баярт зориулан 17ш ном, 3ш хэвлэмэл материалаар
- Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан “Монголын түүхийн домогт хатад” сэдэвт үзэсгэлэнг 17ш номоор тус тус үзэсгэлэн гаргалаа.

Үзэсгэлэн худалдаа

“Улаанбаатар номын баяр 2020” үзэсгэлэн худалдаа 2020.06.05-аас 2020.06.07-ний хооронд “Гэртээ хүсэснээрээ уншъя” уриан дор зохион байгуулагдаж тус үзэсгэлэнд манай номын сан дараах хөтөлбөрийн дагуу оролцлоо.



2020.05.06-нд

1. “Бага насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон номыг хэрхэн сонгох вэ?” сэдэвт цахим уулзалт ярилцлага.
2. “Хүүхдийн уншвал зохих 11ш ном” үзэсгэлэн
3. “Дөрвөн бэрхтэй уншлага” танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн,
4. Хуучин номын худалдаа
5. Номын сангийн уншигчийн карт нээх үйлчилгээ үзүүлсэн бол


2020.06.06-нд

1. Насанд хүрэгчдэд зориулсан “Таны уншвал зохих 15 ш ном” үзэсгэлэн
1. 1946-1959 оны уран зохиолын 22ш номын үзэсгэлэн
2. Хуучин номын худалдаа
3. Номын сангийн уншигчийн карт нээх үйлчилгээ



2020.06.07-нд

1. Maker space, Америк мэдээллийн төвийн үйл ажиллагааны талаар сурталчлан танилцуулах
2. Гадаад хэл дээрх насанд хүрэгчид болон хүүхдэд зориулсан 45ш номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.



Тус арга хэмжээнд нийт 150ш танилцуулга хуудас тарааж, 5 удаа 93ш номын үзэсгэлэн гаргаж, 14 хүнд карт нээн, “Дөрвөн бэрх”-тэй уншлага 2 удаа зохион байгуулан 20 хүн дөрвөн бэрх хаяж 12 хүн асуултад зөв хариулан байр эзэлсэн. Нийт 250 хүнд номын сангийн үйлчилгээ, салбарын байршил, ном унших арга барил зэрэг чиглэлээр товч мэдээлэл өгч, 20000₮ хуучин номын худалдаа хийж ажилласан байна.

Цахим үлгэр, сургалт:

Хөл хорио тогтоосон байгаа эл үед тус номын сангаас хүүхэд багачууддаа зориулан цахим хуудаснаа Үлгэрийн цаг буланг хөтлөн явуулж:


- Зарааханы үлгэр
- Өөрийгөө бусадтай бүү зүйрлэ
- Эрдэмт гөлөг
- Галыг анх хэрхэн нээсэн үлгэр
- Бар унасан хулгайч
- Үнэг чоно зараа гурав
- Манжингийн үлгэр
- Цэцэн туулай
- Үнэг чоно хоёр
- Доголон шаазгайн үлгэр
- Салан баавгайн үлгэр
- Хаан бадарчин хоёр
- Туулай зараа хоёр
- Эвтэй дөрвөн амьтан

- Улаан малгайт
- Хөхөө шувууны үлгэр
- Бичиг мэддэггүй бамбарууш
- Амьд малгай
- Царцаа намжил,
- Сүүлэнхүү,
- Алт мөнгө хоёр
- "Ангар" агентлагийн уран бүтээлчдийн гаргасан байгаль, нийгмийн шинжлэх ухаан, танин мэдэхүйн сэдвүүдийг багтаасан "Биби хүү"-д тохиолдсон адал явдалт 5 цуврал зэрэг 20 гаруй үлгэрийг номын санчдаар уншуулан, монтаж, эвлүүлэг хийж нийгмийн сүлжээгээр түгээлээ. Мөн Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан MNB-ийн "Ами Тами номын сангаар аялсан нь" баярын нэвтрүүлэгт оролцож номын сангаа танилцууллаа.



Цахим сургалт

- Ухаалаг гар утасны цэнэглэгчийг хэрхэн хийх вэ,
- Генийн шинжлэх ухаан - коронависрусын тухай,
- Интернетийг хэрхэн ашиглах вэ?
- Электрон багаж, хэрэгслийг ашиглах арга зүй, техник,
- Шинжлэх ухааны тухай бидний мэддэггүй ба мэддэг зүйлс,
- Дахин загварчилсан хувцас,
- Дахин загварчлах нь,
- ЛегоМайндСторм зэрэг сэдвүүдээр 23 удаа 498 минутын бичлэг хийж олон нийтийн сүлжээгээр цацжээ.



Эргүүл:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03/846 тоот албан бичгээр өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн нийт албан хаагчид 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд хуваарийн дагуу Баянгол дүүргийн 9 хэсэгт эргүүлээр ажилласан.

Тус номын сангийн албан хаагчид 02-р сарын 20-ны өдрөөс 06-р сарын 04-ны өдрийн хугацаанд байгууллагаас боловсруулсан эргүүлээр ажиллах хуваарь, албан хаагчдын зааварчилгаа, бүсчилсэн маршрутын дагуу нийт 70 албан хаагчид эргүүлээр ажиллан давхардсан тоогоор 231 аж ахуй, нэгж байгуулгуудад ариутгал цэвэрлэгээ хийсэн эсэхэд хяналт тавьж ариутгал халдваргүйжүүлэлт хийгээгүй аж ахуй нэгжийг холбогдох газарт нь мэдээлж, гудамж талбайд ил нус цэр хаясан, маск зүүгээгүй 6000 гаруй иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгч шаардлага тавин тайлан мэдээгээ тогтмол хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Мөн Өлзийтийн шалган нэвтрүүлэх постон дээр хоёр ажилтан иргэдийг мэдээлэлээр ханган эргүүлээр ажиллалаа.



5.2. Цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт. Үүнд:

- Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангийн нийтийн уншлагын танхимын ойрын фондны дээврээс ус гоожин цөмөрч байгаа бөгөөд цахилгааны шугамтай хамт байгаа тул эрсдэл дагуулах өндөр магадлалтай байна.



ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
ЗАХИРАЛ

Д.ИНДРА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН

Б.Бадмаарагчаа